



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381

Утас/Факс: (976-51) 26 23 50,

Цахим шуудан: info@pcsp.gov.mn,

Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2023.06.29 № А-1/1278

танай 2023.02.14-ны № 01/2912 -Т

Тайлан хүргүүлэх тухай

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн эхний хагас жилийн тайланг гарган хүргүүлж байна.

Тайланг “Авлигын эсрэг үндэсний сүлжээ” <http://khutulbur.iaac.mn/iaac/plan/> цахим системийн “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” хэсэгт оруулан баталгаажуулсан болно.

Хавсралт 49 хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

123006159

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ – ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

(2023 оны эхний хагас жилийн байдлаар)

2023-06-23

Улаанбаатар хот

Д/ д	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Хэрэг- жих хугацаа	Хариуцах (1.) болон хамтран ажиллах (2.) байгуул- лага нэгж, албан тушаалтан	Хэрэгжилт, хувь
Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх						
1	1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх	<ul style="list-style-type: none"> – Олон хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байдал; – Баримтжуулсан байдал; – Үр дүнг тооцож, тайлагнасан байдал (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо); – Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх. 	<ul style="list-style-type: none"> – Олон нийтэд түгээн сурталчилж, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна; – Баримт нотолгоонд үндэслэн үр дүнг тайлагнасан байна; – Харьяа төрийн өмчит компани, үйлдвэрийн газрыг хамруулах. 	Жилдээ, тухай бүр	1. Захиргаа, удирдлагын хэлтэс (ЗУХ), Хууль, эрх зүйн хэлтэс (ХЭЗХ). 2. Хэлтэс, Алба, Авлигатай тэмцэх газар	2023 оны эхний хагас жилийн байдлаар Авлигатай тэмцэх газраас дараах мэдээлэл, сурталчилгааны материалыг хүлээн авч, олон нийтийн сүлжээн дэх байгууллагын цахим хуудас, фэйсбүүк пэйж хуудас, байгууллагын мэдээллийн самбар, бусад хэлбэрээр түгээн сурталчилсан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> – 110 дугаарын утасны постер, – Авлигын эсрэг НЭГДЬЕ аяны лого, постерууд, фэйсбүүк пэйж хуудасны нүүрэнд тавих хуудас, видео сурталчилгаа, шторк, бичлэг; – Авлигын эсрэг хууль тогтоомжоор хуульчилсан хориглолт, хязгаарлалттай холбоотой сурталчилгааны хэвлэмэл хуудас (брошур); – Авлига, албан тушаалын гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн кэйс бүхий 2 төрлийн эмхэтгэл ном. “Авлигын эсрэг НЭГДЬЕ” аяны хүрээнд АТГ-аас бэлтгэн ирүүлсэн материалыг олон нийтэд түгээх, уг аянд нэгдэх талаар салбар ЭБАТ-уудыг фэйсбүүкийн “ТӨБЗГ-ын салбар ЭБАТ” хаалттай группээр дамжуулан мэдээллээр хангаж, чиглэл өгөн ажилласан. Ном, товхимол, эмхэтгэл, брошур зэргээр шинээр томилогдсон салбар ЭБАТ-уудыг хангаж, үйл

					(АТГ). ажиллагаандаа ашиглах, нийтийн хүртээл болгон түгээх боломжоор хангасан. Мөн авлигын эсрэг хууль тогтоомж, мэдээллийг байгууллагын мэдээллийн самбар, дотоод сүлжээнд байршуулан олон нийтэд болон албан хаагчдад мэдээлэн танилцуулж байна. Хэрэгжилт – 100 хувь.	
2	1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах	– Зохион байгуулсан өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа гэх мэт арга хэмжээний тоо; – Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	– 2 < соён гэгээрүүлэх арга хэмжээ; – Зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг 2 удаа тайлагнасан, нотолсон байна.	Хагас, бүтэн жилдээ	1. ЗУХ, ХЭЗХ, Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (ТӨУЗХ). 2. Хэлтэс, Алба.	Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор “2023-2024 оныг авлигатай тэмцэх жил” болгон зарласан. Уг жилийн ажлын хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Авлигатай тэмцэх 5 үйл ажиллагаа”-г дэмжин сурталчлах, түүний хүрээнд харьяа байгууллагад жилийн ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах талаар анхаарал хандуулах агуулгатай мэдээлэл, чиглэл хүргүүлсэн. Үүнтэй холбоотойгоор ЗГХЭГ-ын даргын уулзалтад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 93 хуулийн этгээдийн удирдлагыг оролцуулах ажлыг зохион байгуулсан. “Шүүр” ажиллагааг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авах чиглэлээр ЗГХЭГ-аас ирүүлсэн чиглэлийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ зохион байгуулж, ЗГХЭГ-т ТӨБЗГ-ын 2023.04.06-ны өдрийн А-1/638 дугаартай албан бичгээр хариу мэдээлэл, танилцуулга хүргүүлэв. Энэ ажлын хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад “Шүүр” ажиллагааны хэрэгжилтийг хангах, шаардлагыг зөрчиж томилогдсон этгээдийн талаарх мэдээллийг нэгтгэн дүгнэж танилцуулах ажлын хэсгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/26 дугаар тушаалаар томилон ажиллуулсан. ТӨБЗГ-аас 100 хувь болон тодорхой хувиар төрийн өмчийн Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 71 хуулийн этгээдээс холбогдох мэдээлэл, судалгааг гаргуулан нэгтгэж, дүгнэлт хийв. 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн байдлаар төрийн өмчит 60 хуулийн этгээдийн 903 ажилтан албан хаагчдын холбогдох мэдээллүүдийг нэгтгэн ирүүлснээс

					<p>дүгнэхэд 44 албан хаагч зөрчилтэй буюу шаардлагыг зөрчиж томилогдсон гэж мэдээлсэн байна. (Уг арга хэмжээний нэгдсэн танилцуулга, дүгнэлт, авч буй арга хэмжээний талаар хавсралтаар холбогдох материалыг хавсаргав).</p> <p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж байгаа “Авлигын эсрэг НЭГДБЕ” олон нийтэд чиглэсэн нөлөөллийн аянд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нэгдэж, Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэлийн дагуу бэлтгэж ирүүлсэн сурталчилгаа, материалыг олон нийтэд түгээхэд өөрийн байгууллагын мэдээллийг олон нийтэд хүргэдэг боломжит сувгаараа дамжуулан түгээж ажиллаж байна. Тухайлбал, https://www.facebook.com/pcsp.gov.mn байгууллагын фэйсбүүк пэйж хуудас, байгууллагын албан ёсны https://pcsp.gov.mn цахим хуудас гэх мэт. Аяны сурталчилгааны зурагт хуудсуудыг байгууллагын цахим хуудасны “Авлигын эсрэг үйл ажиллагаа” цэсийн “Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” https://pcsp.gov.mn/?page_id=5660# хэсэгт байршуулсан болно. Цаашид сүүлийн хагас жилд энэ аяныг өргөжүүлэн дэмжиж ажиллахаар төлөвлөөд байна.</p> <p>Хэрэгжилт – 70 хувь.</p>	
3	1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах.	<ul style="list-style-type: none"> – Мэдээллийн олон талт байдлыг хангаж, түгээн сурталчлах; – Сар бүрийн шинэчилсэн мэдээллийг нотолж тайлагнасан байх. 	<ul style="list-style-type: none"> – Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлэх; – Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх. 	Жилдээ, тухай бүр	<ol style="list-style-type: none"> 1. ЗУХ. 2. Хэлтэс, Алба, Авлигатай тэмцэх газар (АТГ), ЗГ-ын 9-р 	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын байрладаг Засгийн газрын 9 дүгээр байранд байршин үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Төрийн худалдан авах ажиллагааны газар, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Мал эмнэлгийн ерөнхий газар гэсэн 3 байгууллага тус бүрд “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг тус тус ажиллуулж, олон нийтийг Авлигатай тэмцэх газрын мэдээллээр хангаж байгаа болно. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн байгууллагуудад байршуулан ажиллуулж байгаа уг самбарыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тусгайлан олгоогүй болно. (Тус байршилд 3 самбар байгаа нь хангалттай гэж АТГ-ын холбогдох албан тушаалтнаас тухайн самбарыг байгууллагуудад хүлээлгэж өгч байх үед хариу авч байсан болно)</p>

					байр дахь бусад төрийн байгууллага.	<p>Авлигатай тэмцэх газраас хэвлүүлэн тараасан “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” зурагт хуудсыг байгууллагын нэгж хэсгүүдэд байршуулан сурталчилж байна (Холбогдох гэрэл зургийг хавсаргав).</p> <p>Мөн харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнаар шинээр томилогдсон болон зарим эрх бүхий албан тушаалтнуудад уг зурагт хуудсыг тараан түгээж, тухайн байгууллагадаа сурталчлан таниулах талаар чиглэл өгсөн болно.</p> <p>Мөн “Авлигыг мэдээлэх утас 110” цахим постерыг байгууллагын цахим хуудас, болон нийгмийн сүлжээн дэх фэйсбүүк пэйж болон байгууллагын албан ёсны цахим хуудсандаа байршуулан олон нийтэд сурталчилж байна.</p> <p>Хэрэгжилт – 100 хувь.</p>
4	1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх	<ul style="list-style-type: none"> – Зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх; – Сурталчилгааны материалын тоо; – Олон нийтэд хүргэсэн байх; – Авлигыг мэдээлэх 110 дугаар, Шүгэл үлээхэд НЭГДЬЕ агуулгыг оруулсан байх. 	<ul style="list-style-type: none"> – Сурталчилгааны хуваарь батлагдсан байна; – Бэлтгэсэн сурталчилгаа 2< байна; – Олон нийтэд хүргэсэн байна; – Авлигыг мэдээлэх 110 дугаар, Шүгэл үлээхэд НЭГДЬЕ агуулгыг сурталчилсан байна. 	Жилдээ, тухай бүр	<ol style="list-style-type: none"> 1. МТА (Мэдээлэл, техноло-гийн алба). 2. Хэлтэс, Алба. 	<p>Сүүлийн хагас жилд хэрэгжүүлэхээр бэлтгэж байгаа тул эхний хагас жилийн ажлыг хойшлуулсан.</p> <p>Хэрэгжилт – Хугацаа болоогүй, хүлээгдэж байгаа.</p>
Зорилт 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг сургалтад хамруулах						
5	2.1.Төрийн албанд шинээр томилогдсон	– Сургалтад хамрагдсан	– Шинээр томилогдсон	I, III улиралд	1. ЗУХ.	Шинээр томилогдсон албан хаагчдад албан ёсны сургалт хийгдээгүй. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

	албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамруулсан байх	албан хаагчдын тоо.	албан хаагчдыг бүрэн хамруулсан байх, 9<.		2. Хэлтэс, Алба, АТГ.	асуудлаар ярилцлага хийх, анхаарах асуудлыг хэлж, зөвлөгөө, арга зүйгээр хангаж ажилласан. Хэрэгжилт – 30 хувь.
6	2.2.Байгууллагын (хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг байгууллагад гэх мэт) авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах	– Сургалт, соён гэгээрүүлэх, мэдээлэл сурталчилгааны үйл ажиллагаанд хамрагдалт, тоогоор; – Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлах.	– Хамрагдалт – 30< оролцогч; – Өөрийн байгууллагын нөөц бололцоог ашигласан байна; – Нотолгоонд суурилж, тайлагнасан байна.	Жилдээ, тухай бүрд	1. ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ. 2. Хэлтэс, Алба.	Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор “2023-2024 оныг авлигатай тэмцэх жил” болгон зарласан. Уг жилийн ажлын хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Авлигатай тэмцэх 5 үйл ажиллагаа”-г дэмжин сурталчлах, түүний хүрээнд харьяа байгууллагад жилийн ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллахад анхаарал хандуулах талаар мэдээлэл, чиглэл хүргүүлсэн. Үүнтэй холбоотойгоор ЗГХЭГ-ын даргын уулзалтад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 93 хуулийн этгээдийн удирдлагыг оролцуулах ажлыг зохион байгуулав. “Шүүр” ажиллагааг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авах чиглэлээр ЗГХЭГ-аас ирүүлсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ЗГХЭГ-т ТӨБЗГ-ын 2023.04.06-ны өдрийн А-1/638 дугаартай албан бичгээр хариу мэдээлэл, дүгнэлт, танилцуулга хүргүүлэв. (Уг арга хэмжээний нэгдсэн танилцуулга, дүгнэлт, авч буй арга хэмжээний талаар хавсралтаар холбогдох материалыг хавсаргав). “Шил ажиллагаа”-ны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай Ерөнхий сайдын 2023.04.17-ны өдрийн албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл, цалин урамшууллыг ил тод болгож, https://shilen.gov.mn цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулалтаар ханган ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлтэй холбоотой 1551 мэдээлэл уг цахим системд бүртгэгдээд байна. Мөн ТӨБЗГ-тай байгуулсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан түрээслэгчдийн судалгааг гарган https://shilen.gov.mn/ сайтад байршуулсан. Уг мэдээлэлд 2017-2023 оны 2944 мэдээлэл хамрагдан нээлттэй

						<p>мэдээлэгдээд байна.</p> <p>“Шүгэл” ажиллагаанд төрийн албан хаагчид, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нөлөөллийн аяныг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж байгаад тус байгууллага нэгдэж, холбогдох нөлөөллийн мэдээлэл, сурталчилгааг төрийн албан хаагчдаар дамжуулан олон нийтэд түгээх ажлуудыг хэрэгжүүлж байна.</p> <p>Хэрэгжилт – 70 хувь.</p>
Зорилт 3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох						
7	3.1. Байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх	<ul style="list-style-type: none"> – Гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар холбогдох заалтыг тусгасан эсэх; – Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан эсэх; – Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг тусгасан эсэх; – Гэрээний бүртгэл, хяналтыг хэрэгжүүлсэн байх. 	<ul style="list-style-type: none"> – Гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар холбогдох заалтыг тусгасан байна; – Байгуулсан гэрээнд үзлэг, шалгалт хийж, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд дүгнэлт гаргасан байна; – Гэрээний бүртгэл хийсэн байна. 	Гэрээ хийгдэх тухай бүрд	<ol style="list-style-type: none"> 1. ХЭЗХ, ЗУХ. 2. Хэлтэс, Алба. 	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай байгуулж байгаа гэрээнд гэрээний эрх зүйн болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх агуулга бүхий заалт тусгагдаж байгаа байдалд хяналт тавьж, гэрээний бүртгэлээр тавих хяналтыг сайжруулахад анхаарч байна.</p> <p>Хэрэгжилт – 70 хувь.</p>
8	3.2. “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон	<ul style="list-style-type: none"> – Олон нийтийн хяналтад хамруулах чиглэл; 	<ul style="list-style-type: none"> – Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлээ тодорхойлсон 	III-IV улиралд	<ol style="list-style-type: none"> 1. ХЭЗХ, ЗУХ. 	<p>Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг байгууллагын албан хаагчдад дотоод сүлжээгээр, олон</p>

	<p>нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Сургалт, мэдээлэл, сурталчилгааны тоо; - Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлсэн эсэх, тайлан, зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлсэн эсэх; - Шаардлагатай төсвийг байгууллагын төсөвт тусгасан эсэх. 	<p>байна;</p> <ul style="list-style-type: none"> - Сургалт, мэдээлэл, сурталчилгаа хийгдсэн байна – 1<; - 1< хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлсэн байна; - 2024 оны төсөвт шаардлагатай төсвийг тусгах арга хэмжээ авсан байна. 	<p>2. Хэлтэс, Алба.</p>	<p>нийтийн хүрээнд мэдээллийн самбараар дамжуулан сурталчлан мэдээлсэн.</p> <p>Уг журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт 2023 оны төсөвт тусгагдаагүй. Харин 2024 оны төсвийн төсөлд тусгахаар бэлтгэж байна.</p> <p>Хэрэгжилт - Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.</p>
--	---	--	--	-------------------------	--

Зорилт 4. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах

<p>9</p>	<p>4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м.)</p>	<ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх. 	<ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байна; - Нотломж бүхий мэдээллээр тайлагнасан байна. 	<p>II, IV улиралд</p>	<p>1. ЗУХ, ТӨУЗХ, ХЭЗХ.</p> <p>2. Бусад хэлтэс, Алба.</p> <p>Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбоотой хэрэгжүүлж байгаа “Шил ажиллагаа”-ны хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл, цалин урамшууллыг ил тод болгож, https://shilen.gov.mn цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулалтаар ханган ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлтэй холбоотой 1551 мэдээлэл уг цахим системд бүртгэгдээд байна.</p> <p>Мөн ТӨБЗГ-тай байгуулсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан түрээслэгчдийн судалгааг гарган https://shilen.gov.mn сайтад байршуулсан. Уг мэдээлэлд 2017-2023 оны 2944 мэдээлэл хамрагдан нээлттэй мэдээлэгдээд байна.</p> <p>“Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын шинэчилсэн найруулгын төсөл, “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон</p>
----------	--	--	--	-----------------------	---

					<p>шалгаруулах нийтлэг журам"-ын төсөл, "Төрийн өмчит хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам"-ын төсөл болон холбогдох мэдээлэл, танилцуулгыг боловсруулан 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-1/209 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар уг журмын төслүүдийг хэлэлцэж, Засгийн газрын 2023 оны 84, 85, 86 дугаар тогтоолоор тус тус баталсан. Уг журмуудыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Түүнчлэн, ТӨБЗГ-ын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор "Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цагийн цалин хөлсний хэмжээг тооцох оролцоонд суурилсан холимог аргачлал"-ыг баталсан нь цалин хөлсний шударга тогтолцоог хэрэгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, компанийн засаглалыг сайжруулахад нэмэр болох зүй зохистой арга хэмжээ болсон. Уг аргачлалыг мөрдөн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ аван ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд, ТӨБЗГ-т хүлээж авсан нийт 119 өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 80.7 хувьтай, 23 өргөдөл, гомдлыг шийдвэрлэхээр судалж байна. ТӨБЗГ-ын 2023 оны дотоод хяналт шалгалт, аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хариутай бичгийн шийдвэрлэлтэд тус тус дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.</p> <p>Хэрэгжилт – 100 хувь.</p>	
10	4.2.Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан	<ul style="list-style-type: none"> – Хариуцдаг салбарын хэмжээнд 2-оос доошгүй арга хэмжээг зохион байгуулсан байх; – Хэлэлцүүлэг, уулзалтын үр 	<ul style="list-style-type: none"> – Урьдчилан сэргийлэх чиглэлээр 2< арга хэмжээг зохион байгуулсан байна; 	<p>Үү улиралд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хэлтэс, Алба. 2. АТГ, Бусад 	<p>Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж, авлигатай тэмцэх 5 үйл ажиллагаа буюу "Шүгэл ажиллагаа", "Шүүр ажиллагаа", "Шувуу ажиллагаа", "Шилжүүлэн авах ажиллагаа", "Шил ажиллагаа"-г тус тус хэрэгжүүлэхээр тогтсонтой холбоотойгоор Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангийн хийсэн уулзалтад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдах бүрэлдэхүүн, зарим</p>

	байх	<p>дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх;</p> <ul style="list-style-type: none"> - Тайланд нотломжийг хавсаргасан байх. 	<ul style="list-style-type: none"> - Уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнд тодорхой арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжүүлэх; - Нотломж бүхий мэдээллээр тайлагнасан байна. 		байгуул-лага.	<p>албан хаагчид, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 93 хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захирлуудыг бүрэн оролцуулах арга хэмжээг зохион байгуулав. Уулзалтын үеэр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд "Шүүр" ажиллагааны хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих систем", "Шүүр ажиллагаа"-ны талаарх танилцуулга, мэдээлэл хийгдэж, бусад холбогдох мэдээллүүдийн талаар санал солилцож, нэгдсэн удирдлага, ойлголтоор хангагдлаа.</p> <p>Мөн Засгийн газраас "Авлигатай тэмцэх жил" зарласантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарын урилгаар БНСУ-ын Хууль тогтоомжийн сайд асан Ли Сонг Ёны өөрийн улсын авлигатай тэмцэж буй тэргүүн туршлагаас танилцуулах, мэргэжлийн зөвлөгөө өгөх зорилгоор төрийн албан хаагчдад зориулан 2023.05.12-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан лекцэд тус байгууллагын хэлтсийн дарга, ахлах мэргэжилтнүүдийг оролцуулав.</p> <p>Хэрэгжилт – 70 хувь.</p>
11	4.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	<ul style="list-style-type: none"> - Үнэлгээ хийхэд шаардлагатай судалгаа хийсэн байх; - Үнэлгээ, хувиар Бодитой үр дүнг тооцсон байх; - Дүнгийн мөрөөр авах арга хэмжээг тодорхойлсон эсэн; - Тайланд нотломжийг хавсаргасан байх. 	<ul style="list-style-type: none"> - Сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэсэн, мэдээлсэн байна; - Үнэлгээ – 70< хувь. - Судалгааны дүнгийн мөрөөр холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; - Нотломж бүхий мэдээллээр тайлагнасан 	I, IV улиралд	<ol style="list-style-type: none"> 1. ЗУХ. 2. Хэлтэс, Алба, Бусад байгууллага. 	<p>Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчдээс үнэлгээ авах судалгааны ажлыг байгууллагын 2022 болон 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсанаар 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 1 дүгээр сарын 16-ны хооронд (он дамнаж) зохион байгуулахаар агентлагийн даргын удирдамж гарган судалгааны ажлыг зохион байгуулсан. Уг судалгаагаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цаашид авах арга хэмжээг тодорхойлохоор төлөвлөсөн. Судалгааны дүн, дүгнэлт батлагдсан удирдамжийн дагуу 2023 оны 1 дүгээр сард танилцуулагдсан. (Хэрэглэгчийн үнэлгээний удирдамж, гарсан дүгнэлтийг файлаар хавсаргав).</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргаар батлуулсан удирдамж, асуулгын дагуу "Хэрэглэгчийн үнэлгээ"-г үйлчилгээ үзүүлдэг харьяа байгууллагуудаас цахимаар болон цаасаар салбар, чиг үүрэг, үйлчилгээний</p>

			байна.			чанар, хүртээмжийн талаар 15 асуулгын хүрээнд 63 иргэнээс санал асуулга авч, дүнг нэгтгэн дүгнэсэн. Судалгаанаас дүгнэхэд, 63 иргэн буюу 91.5 хувь нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун гэсэн хариултыг өгч, дундаж оноо 4.1 буюу сайн гэж үнэлсэн байна. Үнэлгээний дүн, дүгнэлтийн мөрөөр тодорхой асуудалд анхаарч, сайжруулах талаарх зөвлөмжийг хэрэгжүүлэхэд 2023 оны үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаж байна. Хэрэгжилт – 100 хувь.
12	4.4.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх.	– Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг тайлагнасан байх.	– Зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна.	Жилдээ, тухай бүр	1. Хэлтэс, Алба. 2. АТГ, ТӨХЭ.	Авлигатай тэмцэх газраас ТӨБЗГ-т ирүүлсэн албан бичгийг удирдлагын заалтаар холбогдох хэлтэс, албан хаагчид ажлын чиглэлийн дагуу шийдвэрлүүлэхээр хуваарилан зохион байгуулан албан бичиг, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж байгаа байдалд хяналт тавьж ажиллав. 2023.06.27-ны өдрийн байдлаар ТӨБЗГ-т АТГ-аас нийт 54 албан бичиг ирүүлсэн бүртгэлтэй байгаа бөгөөд тэдгээрээс 34 нь хариутай бичиг байна. Хариутай бичгийн 30 нь шийдвэрлэгдсэн бөгөөд шийдвэрлэлт 88.7 хувьтай байна. ТӨБЗГ-т хүлээн авсан албан бичгийн агуулга: 1. Харилцсан бичиг (хүсэлт, хариу хүргүүлэх, материал буцаах, хамтран ажиллах тухай г.м.) – 41; 2. Чиглэл өгсөн – 3; 3. Зөвлөмж – 0; 4. Мөрдөгчийн мэдэгдэл – 1; 5. Хариуцлага тооцуулах тухай – 0; 6. Материал гаргуулах, нотлох баримт гаргуулах тухай – 9. АТГ-аас тус байгууллагад ирүүлсэн бичгийн зохион байгуулалтын нэгжүүдэд хамаарах хүрээгээр ангилбал: 1. Захиргаа, удирдлагын хэлтсийн чиг үүрэгт хамаарах – 22.22 %; 2. Хууль, эрх зүйн хэлтэст хамаарах – 38.89 %; 3. Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэст хамаарах – 25.93 %; 4. Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэст хамаарах – 0.0 %;

						<p>5. Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын асуудлаар – 12.96 %.</p> <p>Авлигатай тэмцэх газраас тайлант хугацаанд ТӨБЗГ-т бүрэн эрхийнхээ хүрээнд өгсөн 3 чиглэлийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ аван ажиллаж байна, Тайлант хугацаанд зөвлөмж хүлээн аваагүй, мөрдөгчийн 1 мэдэгдэл хүлээн авсан бөгөөд хариу өгөх хугацаа болоогүй байна.</p> <p>Уул уурхайн салбарын төрийн өмчит үйлдвэрийн газруудын гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүн, урамшууллын эрх зүйн орчин, дүрэм журамд өөрчлөлт оруулах асуудлыг хэрэгжүүлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газраас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын нэр дээр 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/16426 дугаар албан бичгээр зөвлөмж ирүүлсэн. Уг зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах талаар “Эрдэнэс Монгол” ХХК-д ТӨБЗГ-аас албан бичгээр чиглэл хүргүүлсэн. Уг чиглэлд мөн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ болон “Монголросцветмет” ТӨҮГ-ын дүрэмд гүйцэтгэх удирдлагатай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх, урамшуулал олгох асуудлыг ТӨБЗГ-ын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-аар зохицуулахаар заасан тул журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа боловсруулан ирүүлэх асуудлыг тусгасан. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан талаарх мэдээллийг ТӨБЗГ-ын 2023.02.17-ны А-1/317 дугаартай албан бичгээр АТГ-т хариу хүргүүлсэн. (Хавсралт файлыг үзэх: Энэхүү тайлангийн 16 дахь заалтад хавсаргасан болно.)</p> <p>Хэрэгжилт – 100 хувь.</p>
13	4.5.Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	– Хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг тайлагнасан байх.	– Мэдэгдлийг хэрэгжүүлж, тайлагнасан байна.	Жилдээ, тухай бүр	1. Хэлтэс, Алба. 2. АТГ, ТӨХЭ.	<p>Тайлант хугацаанд, мөрдөгчийн 1 мэдэгдэл хүлээн авсан бөгөөд хариу өгөх хугацаа болоогүй байна.</p> <p>АТГ-ын 2023.06.14-ний өдрийн 06/10452 дугаартай албан бичгээр ирүүлсэн 2023.06.13-ны өдрийн № 73 дугаар бүхий мөрдөгчийн мэдэгдлийг ТӨБЗГ-т 2023.06.16 хүлээн авч</p>

						зохих арга хэмжээ авахаар судлан ажиллаж байна. Хэрэгжилт – Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, хүлээгдэж байна.
14	4.6.Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	– Зөрчил арилгуулах арга хэмжээ авсан байх.	– Зөрчил арилгах талаар авсан арга хэмжээний үр дүнг тайлагнасан байна.	Жилдээ, тухай бүрд	1. Хэлтэс, Алба. 2. АТГ, ТӨХЭ.	Тайлант хугацаанд, зөрчил арилгуулах албан бичгийг Авлигатай тэмцэх газраас хүлээн аваагүй болно. Хэрэгжилт – Үнэлэх боломжгүй.
Зорилт 5. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх						
15	5.1.Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах	– Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; – Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх; – Тайланд нотломжийг хавсаргасан байх.	– Танилцуулгад хамрагдсан албан хаагч, 100 хувь; – Нотлох баримтаар тайлагнасан байна.	Жилдээ, тухай бүрд	1. ЗУХ. 2. Хэлтэс, Алба.	Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд нийт албан хаагчид, зохион байгуулалтын нэгжээс санал авах ажлыг зохион байгуулж, төлөвлөгөөг боловсруулан баталсан. Төлөвлөгөөг нийт албан хаагчдад дотоод сүлжээнд байршуулан танилцуулах арга хэмжээг авсан. Монгол Улсын Засгийн газраас “Авлигатай тэмцэх жил” зарласантай холбоотой төлөвлөгөөнд зарим тодотголыг жилийн явцад хийх шаардлага үүсэж, нэмэлт арга хэмжээг сүүлийн хагас жилд хэрэгжүүлэхээр байгаа. Төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг үүгээр хуулийн хугацаанд тайлагнаж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлж байна. Мөн уг тайланг Авлигын эсрэг үндэсний сүлжээ http://khutulbur.iaac.mn/iaac/plan/ цахим системийн “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” хэсэгт оруулан Авлигатай тэмцэх газрын хяналт, үнэлгээнд хамруулж байна. Хэрэгжилт – 100 хувь
16	5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал	– Санал тусгасан байх; – Тайланд нотломжийг хавсаргасан байх.	– Нотлох баримтаар тайлагнасан байна.	Жилдээ, тухай бүрд	1. ЗУХ. 2. АТГ.	Уул уурхайн салбарын төрийн өмчит үйлдвэрийн газруудын гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүн, урамшууллын эрх зүйн орчин, дүрэм журамд өөрчлөлт оруулах асуудлыг хэрэгжүүлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газраас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын нэр дээр 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/16426 дугаар албан бичгээр зөвлөмж ирүүлсэн. Засгийн газрын 2022 оны 427,

					<p>428 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын дүрэмд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн харьяанд шилжүүлэн нэгтгэсэнтэй холбоотойгоор тухайн үйлдвэрийн газруудын захиралтай “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г байгуулах, дүгнэх, урамшуулал олгох асуудлыг “Эрдэнэс Монгол” ХХК хариуцаж байна. “Эрдэнэс Монгол” нэгдлийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар ажиллаж байгаа болно.</p> <p>Мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр “Эрдэнэс Монгол” ХХК байхаар Засгийн газрын тогтоолоор тогтоосон.</p> <p>Иймд зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг чиглэл болгож, мөн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ болон “Монголросцветмет” ТӨҮГ-ын дүрэмд гүйцэтгэх удирдлагатай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх, урамшуулал олгох асуудлыг ТӨБЗГ-ын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-аар зохицуулахаар заасан тул журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа боловсруулан ирүүлэх талаар албан бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлсэн. Мөн Авлигатай тэмцэх газарт тус зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан талаарх мэдээллийг хариу албан бичгээр хүргүүлэн ажилласан. (Хавсралт файлыг үзэх)</p> <p>Тайлант хугацаанд, АТГ-аас журам, дүрэм, ёс зүйн дүрмийн төслийг хянаж, санал ирүүлсэн тохиолдолгүй байна.</p> <p>Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг баталсантай холбоотойгоор тус хуулийг сурталчлан таниулах, холбогдох зүйл заалтыг судлан хэрэгжилтийг хангахад чиглэсэн ажлын зохион байгуулалтыг хийхээр төлөвлөж байна (файл хавсаргав).</p>
--	--	--	--	--	---

						Хэрэгжилт – 100 хувь.
17	5.3.Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах (Авлигын эсрэг байгууллагын соёлыг төлөвшүүлэх, удирдлагын манлайлал үзүүлэх, санаачилга өрнүүлэх)	<ul style="list-style-type: none"> – Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; – khutulbur.iaac.mn цахим санд нэмж оруулсан байх, – Авлигын эсрэг зөв ойлголт, хандлагыг төлөвшүүлэх арга хэмжээ авсан байдал; – Тодорхой нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байдал. – Тайлагнасан байх. 	<ul style="list-style-type: none"> – Нэмж хэрэгжүүлэх ажлыг тусгайлан тодотгож, энэхүү төлөвлөгөөнд хавсаргасан байна; – Хэрэгжүүлэх хугацаа – жилийн сүүлийн хагас жилд; – Авч хэрэгжүүлсэн тодорхой арга хэмжээний тоо – 2<. – Нотлох баримтаар тайлагнасан байна. 	Жилдээ, тухай бүрд	<ol style="list-style-type: none"> 1. Удирд- лагууд, ЗУХ. 2. Хэлтэс, Алба. 	<p>“Шүүр ажиллагаа”-г хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт хуулийн этгээдэд санал зөвлөмж хүргүүлж, Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”, 2023 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 174 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цагийн цалин хөлсний хэмжээг тооцох оролцоонд суурилсан холимог аргачлал”-ыг тус тус мөрдүүлэх ажлыг зохион байгуулж байна. Эдгээр журам, аргачлал нь өнөөгийн нөхцөл байдалд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шударга байдал, ил тод байдлыг тус тус хангахад чиглэсэн бодлогын арга хэмжээ, эрх зүйн зохицуулалт болж байгаа болно. Түүнчлэн, ажлын байрны шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтыг тодорхой болгон мөрдүүлэх чиглэл өгөгдсөн байна.</p> <p>Дээрх журмуудыг хэрэгжүүлэх үүднээс ТӨБЗГ-аас гүйцэтгэх захирал нарын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан батлах чиглэлийг төрийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлсэн. Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлуудын албан тушаалын тодорхойлолтыг ТӨБЗГ-аас боловсруулан батлах ажлын хүрээнд холбогдох яамдаас санал авах ажлыг хийж байна.</p> <p>Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн гүйцэтгэх захирал, захирлуудыг хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилон ажиллуулах арга хэмжээг аван ажилллаж байна. Энэ хүрээнд:</p> <p>1.“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын захирлын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын</p>

						<p>газрын даргын 2023 оны А/7 дугаар тушаалаар баталж, захирлын албан тушаалын сонгон шалгаруулалтыг “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын Удирдах зөвлөлөөс зохион байгуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулсны үндсэн дээр ТӨБЗГ-ын 2023 оны 310 дугаар тогтоолоор шалгарсан нэр дэвшигчийг томилон ажлыг хүлээлцүүлсэн.</p> <p>2."Цемент шохой" ТӨХК, "Дорноговь АЗЗА" ТӨХК, "Увс АЗЗА" ТӨХК, "Говь-Алтай АЗЗА" ТӨХК, "Эрдэнэсант АЗЗА" ТӨХК, "Багануур АЗЗА" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд гүйцэтгэх захирлуудыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох талаар удирдамж хүргүүлсний дагуу захирлуудын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан нэр дэвшигчийг томилон ажиллуулсан байна.</p> <p>3."Геологийн судалгаа-шинжилгээний төв" ТӨҮГ-ын захирлыг сонгон шалгаруулах ажлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Геологийн албанаас зохион байгуулан саналаа ирүүлсэн бөгөөд томилох асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хурлаар хэлэлцэн нэр дэвшигчийг томилсон.</p> <p>4."Мэдээлэл, технологийн үндэсний парк" ТӨҮГ, "Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв" ТӨҮГ, "Засгийн газрын автобааз" ТӨҮГ, "Аялал жуулчлалын хөгжлийн төв" ТӨҮГ, "Төрийн орон сууцны корпорац" ТӨХХК захирлуудын сонгон шалгаруулалтыг зарлахаар бэлтгэж, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан холбогдох яамдаас санал авах ажлууд хийгдэж байна.</p> <p>(Холбогдох зарим баримтыг нотлох баримт болгон файл хэлбэрээр хавсаргав)</p> <p>Хэрэгжилт – 100 хувь.</p>
Зорилт 6. Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах						
18	6.1.Төрийн байгууллагын вэб	– Хууль тогтоомжийн	– Вэб сайтад тавигдах	Жилдээ, тухай	1. МТА.	Төрийн байгууллагын вэб хуудсанд тавих шаардлагад нийцүүлэн байгууллагын албан ёсны цахим хуудас болох

	сайтад тавих шаардлагад нийцүүлэн албан ёсны цахим хуудсыг хөгжүүлж, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь хүргэх.	дагуу нээлттэй байдлыг хангах арга хэмжээ авсан байх; – Нээлттэй байдлын хүртээмжийг нэмэгдүүлсэн байх.	шаардлагыг хангах арга хэмжээ авсан байна; – Вэб хуудасны хөгжүүлэлтийг шаардлага, стандартын дагуу хийсэн байна.	бүр	2. Хэлтэс, Алба.	https://pcsp.gov.mn -ийг хөгжүүлж, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь хүргэж байна. Хэрэгжилт – 100 хувь
19	6.2.Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, Авлигын эсрэг хуулийн 6.1.4, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах.	– Хуулийн хугацаанд мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байх; – Хуулийн хэрэгжилт, хувиар.	– Хуулийн хэрэгжилт – 90% хувь.	Жилдээ, тухай бүр	1. ЗУХ, МТА. 2. Хэлтэс, Алба.	Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 2022 оны хэрэгжилтийн байдлын тайланг гаргаж, удирдлагад танилцуулан Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан https://new.unelgee.gov.mn/transparent/ системийн холбогдох хэсэгт оруулан баталгаажуулж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулав. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг 5 чиглэлд хамаарах нийт 46 шалгуур үзүүлэлтээр тайлагнав. Эдгээрээс тайлант жилд тайлагнахгүй, тус байгууллагад хамаарахгүй, мэдээлэл гарах боломжгүй зэрэг шалтгаан, үндэслэлээр 11 заалт бүхий шалгуур үзүүлэлтийг “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” гэсэн үнэлгээний төрлөөр үнэлсэн болно. Хэрэгжилтийн дундаж хувь 100 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” үнэлгээтэй байна. Тайлан болон үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хүснэгт, заавар, аргачлалын дагуу гаргасан. Байгууллагын мэдээллийн нээлттэй байдлын тайлангийн дүнг албан хаагчдад танилцуулах, зарим мэдээллийг нээлттэй мэдээлэх шаардлагатай талаар холбогдох албан хаагчдад зөвлөгөө өгөх, нээлттэй байдлыг боловсронгуй болгох чиглэлээр санал солилцох зэрэг арга хэмжээ авав.

					<p>Байгууллагын мэдээллийн самбарын мэдээллийг шинэчлэн цаг үеийн мэдээллээр тогтмол шинэчлэх, гарын авлага, товхимол, мэдээллийг сурталчилгааны тусгай тавиур хэрэгслийг ашиглан албан хаагчид, олон нийтэд сурталчлан таниулах зэргийг хийж гүйцэтгэв.</p> <p>Шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу төсөв, санхүүтэй холбоотой мэдээллийг холбогдох цахим систем https://shilendans.gov.mn/organization/8324 болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээлсэн. 2023 оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны https://shilendans.gov.mn/organization/8324 цахим системд төсөв, санхүү, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 13 төрлийн 33 мэдээ оруулахаас 30 мэдээг графикт хугацааны дагуу мэдээлсэн 3 мэдээ хугацаа болоогүй хүлээгдэж байна, 1 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн төлөвтэй байна. Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаатай холбоотой нийт 4 төрлийн 13 мэдээг, бусад 7 төрлийн 37 мэдээг мэдээлэхээс бүрэн байршуулан нээлттэй мэдээлсэн байна.</p> <p>Хэрэгжилт – 100 хувь.</p>
--	--	--	--	--	--

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

(2023 оны эхний хагас жилийн байдлаар, өөрийн үнэлгээгээр)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зааврын дагуу “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө”-нд 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх нийт 19 арга хэмжээг тусган баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн явцын дүнг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан үнэлгээний аргачлалын дагуу өөрийн үнэлгээг хийж дор танилцуулав:

Төлөвлөсөн нийт арга хэмжээ – 19; Үүнээс:

- “Үр дүнтэй” буюу 100 хувь хэрэгжсэн арга хэмжээ – 10;
- “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувьтай хэрэгжих шатанд байгаа арга хэмжээ – 4;
- “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30 хувийн хэрэгжилт бүхий арга хэмжээ – 1;
- “Үр дүнгүй” буюу 0 хувь, хэрэгжээгүй, тасарсан – 0;
- “Үнэлэх боломжгүй” буюу өөрсдөөс хамаарахгүй болон хугацаа болоогүй байгаа арга хэмжээ – 4;

Хэрэгжилтийн дундаж хувь, үнэлгээ – 87.3 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээ (өөрийн үнэлгээгээр)-тэй байна.

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

Боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ